

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2017.01.12

Өлгий

Нэг.Ерөнхий зүйл

Аймгийн Аудитын газраас 2016 онд хийж хэрэгжүүлэх ажлын болон аудитын төлөвлөгөөг оны эхэнд боловсруулан, Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэх ажил үйлчилгээний үр дүнгийн гэрээ байгуулан ажиллав.

Тайлангийн хугацаанд Төрийн аудитын байгууллагуудын өмнө 2016 онд дэвшүүлсэн зорилтууд болон Аймгийн Аудитын газрын төлөвлөгөөт ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх, аудитын чанар, үр нөлөө, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллав.

Тайлант онд үндсэн 7 зорилтын хүрээнд 290 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүлэв.

Тайлант онд 260,2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, 11 орон тоо батлагдсанаас 12 орон тоогоор үйл ажиллагаа явуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөөний дагуу 153 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулж дүгнэлт гаргаж, 8 сум, аймгийн төвийн бүгд 78 байгууллагад завсарын аудит хийлээ.

Түүнчлэн 11 сэдвээр гүйцэтгэлийн аудит, 12 сэдвээр нийцлийн аудит хийж төлөвлөсөн аудитиудаа бүрэн хэрэгжүүлэв.

Байгууллага иргэдээс ирүүлсэн 12 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шалган хариуг өгөв.

Аудитын дүнгээр нийтдээ 55227,8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 37,9 сая төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 7836.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 46899,6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулахад чиглэгдсэн 108 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Мөн 196 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, 182 саналын хэрэгжилтийг хангуулав.

Төлбөрийн актын 56,8 хувийг, зөвлөмжийн 87,4 хувийг, албан шаардлагын 99,9 хувийг хэрэгжилтийг нь хангуулсан дүнтэй гарч байгаа боловч хэрэгжих хугацаа болсон актын 90,7 хувийг, зөвлөмжийн 96,7 хувийн хэрэгжилтийг хангуулав. Хэрэгжих хугацаа болоогүй 15 зөвлөмж, 21,8 сая төгрөгийн акт, 5,1 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжиж байна.

Өмнөх оноос он дамжсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээ авлаа.

Санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний хөлс болон төлбөрийн актын дүнгээр орон нутгийн төсөвт нийтдээ 53,0 сая төгрөгийн орлого оруулав.

Хоёр.Санхүүгийн аудитын талаар

Аймгийн Аудитын газар нь тайлант онд санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөөт ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангийн аудитын ажилд СТАУС программыг нэвтрүүлэх зорилт тавьж, амжилттай хэрэгжүүллээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/249 тоот тушаалаар батлагдсан төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх жагсаалтыг үндэслэн аудитор, шинжээч нарын хуваарийг гаргаж тэргүүлэх аудиторoor батлуулж, хэрэгжилтийг нь зохион байгуулж ажиллав.

Төсвийн шууд захирагч 131, аж ахуйн нэгж 7, төсөл сан 3, төсвийн төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1, бүгд 156 санхүүгийн тайланг баталгаажуулж, 40 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 35 санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар төлөвлөв.Үүнээс 2 байгууллага ҮАГ-т шилжиж, 1 байгууллага татан буугдсанаас 153 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 116-г буюу 74,4 хувийг өөрсдийн аудитор, шинжээч нар, 40-ийг буюу 25,6 хувийг гэрээгээр баталгаажуулалт хийлгэв.

Аудитын газрын аудитор, шинжээч нарын баталгаажуулалт хийсэн 113 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлуудыг СТАУС программд бүрэн оруулж, хоёр шатны хяналтыг хэрэгжүүлж, гэрээгээр хийлгэсэн 40 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлуудын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Аудитын дүнгээр 153 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт өгч, 40 байгууллагад итгэл үзүүлж, 35 тайланг түүвэрт хамруулж, 3 байгууллагад тодорхой шалтгаанаар аудит хийгдээгүй болно. Санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн 40 байгууллагад Монгол Улсын Ерөнхий аудиторын гарын үсэгтэй итгэмжлэл олгов.

Санхүүгийн тайлангийн аудитад давхардсан тоогоор 17 хүн ажиллаж, нийтдээ 755 хүн өдөр зарцуулж, ажлын шаардлагаар аудитор, шинжээч нар 1253 илүү цаг ажиллав.

Нийтдээ 153 санал дүгнэлт гаргаснаас 122 байгууллагад зөрчилгүй, 25 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг, 4 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан хариу өгөв.

Аудитын дүнгээр нийтдээ 8284,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 7836,7 сая төгрөгийг буюу 94,5 хувийг аудит хийх явцад залруулга дөёж, 12,3 сая төгрөгийн зөрчлийг төлүүлэхээр акт тогтоож, 435,5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагуудад 60 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж, зөвлөмжийн 95,0 хувийг хэрэгжүүлэв.

Илэрсэн нийт алдаа зөрчлийн 94,8 хувийг бүртгэл тайлагналтай холбоотой, 5,2 хувийг бусад төрлийн зөрчлүүд эзэлж байна. Алдаа зөрчлийн 97,2 хувь нь орон нутгийн байгууллагуудын тайлангаас, 2,8 хувь нь улсын төсвийн байгууллагуудын тайлангаас илэрчээ.

Орон нутгийн байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн 5691,9 сая төгрөг буюу 70,7 хувь нь орон нутгийн өмчийн аж ахуйн

нэгжүүдийн санхүүгийн тайлангаас, 1706,3 сая төгрөг буюу 21,1 хувь нь сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаас, 657,6 сая төгрөг буюу 8,2 хувь нь төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас илэрсэн байна.

Аудит хийсэн байгууллагуудаас 7 төсвийн шууд захирагч санхүүгийн тайланг 10-20 хоногоор, 6 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 9-14 хоногоор хугацаа хожимдуулан ирүүлж Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3 дахь заалтуудыг зөрчсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын дүнгээр хязгаарлалттай, сөрөг санал дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан 31 байгууллагын 47 албан тушаалтанд тодруулбал 18 нягтлан бодогч, эрхлэгчийг байгууллагын даргаар, 11 албан тушаалтанд сумын Засаг даргаар, 18 албан тушаалтанд аймгийн Засаг даргаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг тус тус хүргүүлсэн ба 39 саналыг хэрэгжүүлсэн байна.

-Тус Аудитын газраас 2017 онд хийх санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 2.4.1-д заасан санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалтыг төрөл тус бүрээр санал хэлбэрээр бэлтгэж 6 дугаар сарын 15-нд СТАУС программд оруулсаны дээр ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт шуудангаар болон файл хэлбэрээр цахим сүлжээгээр тус тус хүргүүллээ.

Байгууллагын хүний нөөцийн боломжийг тооцсоны үндсэн дээр 252 байгууллага, төсөл сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхээс 56 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 168 байгууллагыг түүвэрт хамруулж, 27 байгууллагад итгэл үзүүлэн өнжөөхөөр хуваарийн төсөлд тусгалаа.

-Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Аудит хийх жагсаалтыг баталгаажуулах тухай” А/72 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аудитын хуваарийг боловсруулж Тэргүүлэх аудиторoor батлуулж, тушаал гаргаж хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллаж байна.

Завсарын аудитын төлөвлөгөө гаргаж 2016 оны 11, 12 дугаар сард 8 сум, аймгийн төвийн бүгд 78 байгууллагад завсарын аудит хийлээ.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн үр дүнгээр 187,4 сая төгрөгийн, үйлчилгээний төлбөр, актын дүнгээр 43,3 сая төгрөгийн бүгд 231,3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлд тусгаж, үүнээс 230,7 сая төгрөгийн үр өгөөжийн хэрэгжилтийг хангуулав.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Тайлангийн хугацаанд ҮАГ-аар аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 4, өөрсдийн санаачлагаар 5 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийлээ.

ҮАГ-аар аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улсын нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалт, Монгол Улсын Их хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлд тус тус аудит хийж тайланг хугацаанд хүргүүллээ.

Өөрсдийн санаачлагаар Онцгой байдлын хэлтэс, Хот тохижуулах алба, ХХААГазар, "Хала өркени" ОНӨААТҮГазар, "Жана өлке" ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд тус тус аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 1732,9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, үүнээс 0,6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1732,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулах, бусад асуудалд чиглэгдсэн 19 заалт бүхий зөвлөмж өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Жилийн эцсийн мэдээгээр гүйцэтгэлийн аудитын актыг 100 хувь, албан шаардлагын 96,7 хувийг, зөвлөмжийн 87,0 хувийг хэрэгжүүлэв. Хэрэгжих хугацаа болоогүй зөвлөмж, албан шаардлага дараа онд шилжиж байна.

Гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн үр дүнгээр 720,8 сая төгрөгийн, актын дүнгээр 1,6 сая төгрөгийн, бүгд 722,4 сая төгрөгийн санхүүгийн, санхүүгийн бус 4 үр өгөөжийг бүртгэлд тусгаж, үүнээс 722,4 сая төгрөгийн санхүүгийн, санхүүгийн бус 4 үр өгөөжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж, баримтжуулав.

Гүйцэтгэлийн аудитад давхардсан тоогоор 28 хүн ажиллаж 423 хүн өдөр зарцуулжээ.

Аудитын дүнгээс товч дурьдвал: -Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын дүнгээр 2015 онд хэрэгжсэн болон он дамжиж хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн хувийн хэрэгт баяжилт хийж, ҮАГазрын хөрөнгө оруулалтын цахим системд мэдээллийг орууллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлгий сумын 6 квт-ын цахилгаан хуваарилах байгууламжинд хийгдсэн 1578,1 сая төгрөгийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг ашиглалтанд хүлээн авсан боловч ашиглагч байгууллага болох ЦШСГазрын данс бүртгэлд орлого аваагүй байсан зөрчлийг албан шаардлага өгч арилгуулав.

-Аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгээс үзэхэд Орон нутгийн төсвийн нийт орлого төлөвлөснөөс 955,0 сая төгрөгөөр буюу 1,4 хувиар тасарчээ. Үүнээс орон нутгийн урсгал орлого 1192,7 сая төгрөгөөр буюу 21,5 хувиар давж биелэгдэж, тусламж санхүүжилтийн орлого 2147,7 сая төгрөгөөр буюу 3,5 хувиар тасарчээ. Тусламж санхүүжилтийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлсэн орлого 772,3 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэг 516,0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлэг 842,4 сая төгрөгөөр, нийтдээ 2130,7 сая төгрөгөөр дутуу санхүүжигджээ.

Төсвийн зарлага 64787,3 сая төгрөгт хүрч батлагдсан төсвөөс 4,9 хувиар буюу 3369,5 сая төгрөгөөр бага зардал гаргажээ. Төсөвт байгууллагууд 2015 оны эцэст 947,5 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

-Монгол Улсын Их хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардалд 349,8 сая төгрөгийн төсөв хуваарилагдаж, гүйцэтгэлээр 338,3 сая төгрөг зарцуулж 11,5 сая төгрөгөөр хэмнэжээ.

-Онцгой байдлын газарт хийсэн аудитын үр дүнгээр 3,4 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 0,6 сая төгрөгийн зөрчлийг төлүүлэхээр акт тогтоож, 2,8

сая төгрөгийн зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмж өгч хэрэгжилтийг нь хангуулав.

-Хот тохижуулах албаны үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнгээр ОНХСангийн хөрөнгө оруулалтаар авсан 88.7 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнтэй ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна. Аудитын үр дүнгээр 3 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч хэрэгжилтийг хангуулав.

-ХХААГазрын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнгээс үзэхэд 334 толгой уулын бор ямаа, судалгаа шинжилгээний зориулалттай 115 толгой цөм сүргийн ямаа бүртгэлтэй байдаг бөгөөд ямаан сүргийн ашиг шимийн орлого нь малчны хөлс, бусад зардлыг нөхөж чадаагүй, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай ба анхан шатны бүртгэлийн маягт, заавар, аргачлалыг зөрчсөн 146,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулав.

-“Хала өркени” ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнгээс үзэхэд Өлгий сумын ИТХурлын 2014 оны 02 тоот тогтоолоор “Хала өркени” ОНӨААТҮГазрыг үүсгэн байгуулсан боловч анх байгуулахдаа орлого, зардал, ашигт ажиллагаа, эдийн засгийн үр ашгийн үндэслэлийг бодитой тооцоогүйгээс 2014-2015 онуудад 27,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 8,1 сая төгрөгийн авлагатай, 47,0 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Аудитын дүнгээр “Хала өркени” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, өр, авлагыг барагдуулах, Хот тохижуулах албатай нэгтгэх бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Өлгий сумын ИТХурлын дарга, Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлээ.

-“Жана өлке” ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүнгээс Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 137 тоот тогтоолоор битүү захыг “Жана-өлке” ОНӨААТҮГазар болгон ажиллуулсан боловч үйл ажиллагаа нь тогтмолжиж чадаагүй, зогсонги байдалтай ба 2014 онд 102,8 сая төгрөгийн, 2015 онд 66,0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, оны эцэст 448,5 сая төгрөгийн өртэй гарчээ. Аймгийн Засаг даргад “Жана өлке” ОНӨААТҮГазрын үйл ажиллагааг тогтмолжуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлээ.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Тайлангийн хугацаанд ҮАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу бүгд 7 сэдвээр, өөрсдийн санаачлагаар 5 сэдвээр нийцлийн аудит хийлээ.

ҮАГазрын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 2016 оны Орон нутгийн ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах, Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа, үр дүн, Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, Сумын ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд тус тус нийцлийн аудит хийж тайланг хугацаанд хүргүүлээ.

Өөрсдийн санаачлагаар 2016 оны аймаг, сумын орон нутгийн сонгуульд оролцох улс төрийн нам, бие даан нэр дэвшигчдийн сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох, 2016 оны Сумын ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, бие даан дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн

тооцоо судалгаанд дүгнэлт гаргах, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, 2016 оны Орон нутгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүгнэлт гаргах сэдвээр аудит хийлээ.

Нийцлийн аудитын дүнгээр нийтдээ 45207,8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, үүнээс 24,0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 45161,5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулах, бусад асуудалд чиглэгдсэн 29 заалт бүхий зөвлөмж өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

Жилийн эцсийн мэдээгээр нийцлийн аудитын актын 11,7 хувийг, зөвлөмжийн 75,9 хувийг, албан шаардлагыг 100,0 хувь хэрэгжүүлэв. Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн аудитын хэрэгжих хугацаа болоогүй дараа онд шилжиж байгаа 9 зөвлөмж, 21,2 сая төгрөгийн акт хэрэгжилтийн хувь доогуур гарахад нөлөөлж байна.

Нийцлийн аудитын зөвлөмжийн үр дүнгээр 756,7 сая төгрөгийн, албан шаардлагын дүнгээр 47,9 сая төгрөгийн, актын дүнгээр 6,6 сая төгрөгийн, бүгд 811,2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлд тусгаж, үүнээс 811,2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж, хангуулав.

Нийцлийн аудитад давхардсан тоогоор 32 хүн ажиллаж 731 хүн өдөр зарцуулжээ.

Аудитын дүнгээс товч дурьдвал: -Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 4, 11 дүгээр сард хоёр удаа аудит хийлээ. 4 дүгээр сард хийсэн аудитаар улсын төсвийн 23, орон нутгийн төсвийн 121 байгууллага Шилэн дансны тухай хуулийн 1-9 заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн ба аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нарт дээрхи байгууллагуудын дутуу байршуулсан мэдээллийг нөхөн байршуулах, зөрчил, дутагдлыг арилгуулах, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

11 дүгээр сард хийсэн аудитаар зөрчил дутагдлыг давтан гаргасан 149 байгууллагын нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах саналыг албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, үүнээс 143 санал хэрэгжсэн байна. Тухайлбал 132 албан тушаалтанд сануулах, 11 албан тушаалтанд цалин бууруулах арга хэмжээ авчээ.

- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд хийсэн аудитын дүнгээс үзэхэд 4588,6 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3816.3 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 431.6 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төвлөрүүлсэн байна.

Зарим сумын ОНХСан 142.4 сая төгрөгийн өртөг бүхий 32 төсөл, арга хэмжээг иргэдийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад ороогүй байхад батлан хэрэгжүүлж, 2014, 2015 онд хэрэгжсэн буюу дараа онд хэрэгжихээр шилжсэн төсөл, арга хэмжээний нийтдээ 2177.7 сая төгрөгийн санхүүжигдээгүй үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын үр дүнгээр 434.3 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрч үүнээс 2.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 431.5 сая төгрөгийн

зөрчлийг арилгуулах албан шаардлагыг холбогдох байгууллагуудад өгч хэрэгжилтийг хангуулав.

-Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитад Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Байгал орчныг хамгаалах сангийн үйл ажиллагааг хамруулав.

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн аудитад Аймгийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийн биелэлт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төвлөрүүлэлт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, Байгалийн хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавьж буй хяналтын байдалд тус тус аудит хийлээ.

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцох 5 улс төрийн нам, 28 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Үндэсний аудитын газраас ирүүлсэн хавсралт маягтын дагуу гаргаж ирүүллээ. Энэхүү аудитаар сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргалаа.

Аудитын дүнгээр холбогдох хуулиудын тодорхой заалтуудыг зөрчсөн 64 төрлийн 44,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий зорилт арга хэмжээг улс төрийн намууд болон бие даагчид сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгасныг арилгуулахаар тухай бүр албан шаардлага өгч аудитын явцад арилгуулах арга хэмжээ авч, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлсэн 5 нам, 28 бие даагчийн мөрийн хөтөлбөр нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, тус тусдаа дүгнэлт гаргаж, Сонгуулийн тухай хуулинд заасан хугацаанд аймгийн сонгуулийн хороонд хүргүүллээ.

-Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, Үндэсний Аудитын газраас ирүүлсэн сонгуулийн зардлын дээд хэмжээг тооцох аргачилсан зөвлөмжийн дагуу орон нутгийн 2016 оны сонгуульд нам, эвсэл, нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг боловсруулан баталж, ҮАГазар болон аймгийн ИТХурал, нам, эвслүүдэд хүргүүлэв.

-2016 оны ээлжит Сумын ИТХ-ын сонгуульд оролцох 3 улс төрийн нам, 7 бие даан нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хянуулахаар ирүүлсэн ба 3 намын 28 сум дахь салбар болон 7 бие даагчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргалаа.

-Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үйл ажиллагаанд 317,4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, гүйцэтгэлээр 309,4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 7,9 сая төгрөгөөр хэмнэжээ. Сонгуулийн зардлын төсвөөс хэмнэсэн хөрөнгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

-Аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан хянасан аудитын дүнгээс үзэхэд ИТХ-ын сонгуульд 39 мандатын төлөө 4 намын 95 нэр дэвшигч, 12 бие даагч нийт 107 хүн нэр дэвшиж өрсөлдсөн байна. Сонгуулийн хороонд 74 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын

тайлангаа ирүүлж, 33 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа Сонгуулийн хороонд ирүүлээгүй байна.

Нэр дэвшигчид 80 иргэнээс 142.8 сая төгрөгийн, 3 хуулийн этгээдээс 20,0 сая төгрөгийн хандивыг мөнгөөр хүлээн авсан байна. Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д "Төрийн аудитын байгууллага зардлын тайланг хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана" гэж заасны дагуу нэр дэвшигчийн хандивыг нийтэд зарлав.

-Нийгмийн Халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитаар ихэр хүүхдэд олгох нэг удаагийн тэтгэмжийн олголтыг ЭМГ-ын мэдээллийн сан, Нэгдсэн эмнэлгийн архив, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн өрхийн мэдээллийн сангаас тулган шалгаж үзэхэд Өлгий, Бугат, Дэлүүн сумын 9 ихэр хүүхдэд 18,0 сая төгрөгийн тэтгэмжийг нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж зөрчиж олгосоныг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдах боломжтой зорилтот бүлгийн иргэдийн нэгдсэн судалгааг аймаг, сумын хэмжээнд хийж, зорилтот бүлгийг бүрэн хамруулах талаар анхаарах, сангийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөв.

Тав. ИТХ-ын хүсэлтээр болон өөрсдийн санаачлагаар хийсэн аудитын талаар

2016 онд аймгийн ИТХ-ын захиалгаар 3 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөгдсөнөөс 2 сэдвээр гүйцэтгэлийн аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газар, ЦШСГазрын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, Цагдаагийн газрын үйл ажиллагаанд ЦЕГазрын дотоод аудитын шалгалт хийгдсэн тул давхардуулж аудит хийгээгүй болно.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 1,0 сая төгрөгийн зөрчлийг төлүүлэх төлбөрийн акт тогтоож, төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын хяналтыг сайжруулахад чиглэгдсэн 2 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.

-Өөрсдийн санаачлагаар Орон нутгийн 2017 оны төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж төсвийн орлого нэмэгдүүлэх 3, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх 3 санал боловсруулж аймгийн ИТХуралд хүргүүллээ.

Тус аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас 6718.8 сая төгрөгөөр, суурь зарлагыг 16971.7 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна.

2017 оны орлогын төсвийн төслийг 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд нийт дүнгээрээ 291,8 сая төгрөгөөр буюу 3,9 хувиар нэмэгджээ. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг өмнөх оноос 1021.8 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар бууруулсан байна.

Сангийн яам төсвийн зарлагын 60.4 хувийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 39.6 хувийг орон нутгийн орлогын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан бөгөөд 2017 оны төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх

үүсвэрт орон нутгийн орлогоос санхүүжүүлэх хэмжээг нэмэгдүүлсэн нь 2017 онд орон нутгийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн ашиглахаар тооцож төлөвлөжээ.

Орон нутгийн 2017 оны төсвийн орлогын төсөлд дараах саналуудыг оруулав.Үүнд:

1. 2017 оны төсвийн төсөлд цалин хөлсний зардлыг бууруулж төлөвлөсөн боловч цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвараас орох орлогыг нэмэгдүүлсэн нь бодит үндэслэлээр төлөвлөх.

2. Орон нутгийн өмчийн орлого /хөрөнгө худалдсаны болон түрээсийн орлого/-ыг төсөвт байгууллагын өөрийн орлого байдлаар төлөвлөж ирсэн алдааг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.7 дахь заалтуудтай нийцүүлэн залруулж, “төсөвт байгууллагын өөрийн орлого”-оос 38,9 сая төгрөгийг хасч орон нутгийн төсвийн орлогын дансанд шууд оруулахаар “бусад орлого”-д нэмж тусгах.

3.Төсвийн захирагч бүр Төсвийн тухай хуулийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн үүргээ бүрэн биелүүлж татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд оны эхнээс анхаарч, орон нутгийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн ашиглах.

Орон нутгийн 2017 оны төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар дараах саналуудыг оруулав.Үүнд:

1.Сангийн яамнаас хянаж ирүүлсэн 2017 оны орон нутгийн төсвийн суурь зарлага, орон тооны хязгаарт багтаан орон нутгийн байгууллагын төсвийг баталж, Сангийн сайдаас аймгийн Засаг даргад ирүүлсэн төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарах чиглэлийг мөрдөж ажиллах.

2.Сангийн яамнаас бараа үйлчилгээний зардал /цалин хөлс болон бараа үйлчилгээний бусад зардал/-ыг 1.0 хувиар танаж, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулсан байдал нь 2017 онд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасарвал орон нутгийн төсвийн эх үүсвэр дутагдах эрсдэл байгааг зөв тооцож, тэвчиж болох бараа үйлчилгээний зардлыг бууруулж төлөвлөх, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоодын хяналтыг сайжруулах.

3.Орон нутгийн өмчийн орлогыг төсвийн орлогын дансанд шууд оруулахтай холбогдуулан Орон нутгийн өмчийн газрын төсвийг 100% төсвөөс санхүүжүүлдэг болох, өмчийн орлогыг хяналтгүй, үр ашиг муутай зарцуулж ирсэн зөрчлийг арилгаж, үр өгөөжийг дээшлүүлэх.

Байгууллага, иргэдээс нийтдээ 12 өргөдөл, хүсэлт хүлээн авч үүнээс 7 өргөдлийн мөрөөр аудит хийж, бусад өргөдөлд зохих хариуг өгч хугацаанд нь шийдвэрлэв.

Зургаа. Дотоод ажлын талаар

6.1. Албан харилцаа, өргөдөл гомдолын шийдвэрлэлт: -2016 онд Үндэсний аудитын газар болон бусад байгууллагуудад хандсан нийтдээ 296 албан бичиг гарсаныг явуулсан бичгийн бүртгэлд тусгав.

Үндэсний аудитын газарт хүргүүлсэн 30 албан бичгийн шуурхай байдлыг хангах үүднээс тухай бүрт нь цахим шуудангаар давхар хүргүүлэв.

Үндэсний аудитын газарт 11, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 5, аймгийн Засаг даргад 12, бусад байгууллагуудад 30 удаа аудитын тайланг хүргүүлжээ.

Нийт 263 албан бичгийг хүлээн авч ирсэн бичгийн бүртгэлд тусгасан ба цахим шуудангаар хүлээн авсан албан бичгийн бүртгэлийг тусад нь хөтлөв. Үүнээс 8 албан бичгийг шуудангаар, 92 албан бичгийг цахимаар, 163 албан бичгийг шууд хүлээн авч бүртгэв. Байгууллагуудын хүсэлтийн дагуу аудитын 12 тайланг хувилж олгов.

Тэргүүлэх аудиторын 24 тушаал гарсаны 8 нь аудитын тайланг баталгаажуулах тухай, 5 нь хөрөнгө зарцуулах тухай, 2 нь ажилтнуудад чөлөө олгох тухай, 9 нь бусад асуудалтай холбоотой тушаал байна.

Нууцтай холбоотой ирсэн болон явуулсан 120 албан бичгийг тусад нь бүртгэл хөтөлж, хадгалж байна. Нууцтай холбоотой хийгдсэн 3 аудитын тайланг нууцын тамга дарж тусгай сейфэнд хадгалж байна.

Оны эхэнд бүх ажилтнуудаас нууцын баталгааг гаргуулан авч албажуулсаны дээр санхүүгийн тайлангийн аудитад ажилласан аудитор, шинжээч нараас ёс зүйн баталгааг, аудит хийх бүрт сонирхолын зөрчилгүй болох талаарх баталгааг тус тус гаргуулан авч албажуулж байна.

Байгууллагын 11 албан хаагчын Хувийн ашиг сонирхол, Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулинд заасан хугацаанд нь гаргуулан авч нэгтгэн, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэв.

Тайланд онд аймгийн ЗДТГазраас 3 м/кв жижиг өрөө авч архивын өрөө болгон тохижуулснаар ажилтнуудын өрөөний сейф, хананы шүүгээнд хадгалагдаж байсан байгууллагын архивын бүх мемориал баримтуудыг нэг дор архивын стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдлээ.

Эхний хагас жилд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын 153 тайланг 61 боть нэгж болгон, гүйцэтгэл болон нийцлийн аудитын 8 тайланг 12 боть нэгж болгон тус тус нэгжилж үдэж архивын нэгж болгон байгууллагын архивт шилжүүлэв.

6.2. Мэдээллийн технологийн талаар: -Аудитын газар нь 2016 онд ҮАГ-аас интернетийг 2 GB-ийн хурдаар авч, дотоод сүлжээг өдөр тутмын ажилдаа ашиглаж байна.

Дотоод сүлжээг ашиглан ажилтнууд хороондоо болон төрийн аудитын байгууллагын систем дотор мэдээллийг хурдан шуурхай дамжуулах, мэдээлэл солилцох, хүлээн авах, тайлан мэдээг хянах боломж бүрдсэн.

ҮАГ-аас зохион байгуулсан видео хурал, онлайн сургалтанд тухай бүрт нь тогтмол оролцож байна.

Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлуудыг хэрэгжүүлэх, хянах, нэгтгэж удирдах үйл ажиллагааг СТАУС программ хангамжийн тусламжтайгаар цахим хэлбэрээр хэрэгжүүлэх явцад программ гацах, удаан ажиллах, сүлжээнээс гарах зэрэг хүндрэл аудитын явцад удаа дараа тохиолдож байв. СТАУС программыг нэвтрүүлсэнээр аудитор, шинжээч нарын гар ажиллагаа багасч, мэдээллэлийг цахим хэлбэрээр хийж, хадгалах нөхцөл бүрдэж байна.

6.3. Бусад ажлын талаар: -Тайланд онд Удирдлагын зөвлөлийн хурлыг 17 удаа хуралдуулж цаг үеийн асуудал болон аудитын дүнг хэлэлцэж баталгаажуулав.

Долоо хоногийн даваа гариг бүр өглөөний шуурхай зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж өнгөрсөн долоо хоногийн ажлын дүнг хэлэлцэн, тухайн долоо хоногт хийх ажлын чиглэлийг тодотгон ярилцаж хэвшсэн нь тодорхой үр дүнгээ өгч байна.

Тэргүүлэх аудитор Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, Засаг даргын Зөвлөлийн хуралд зөвлөх эрхтэй тогтмол оролцож төсөв, санхүү, хөрөнгөтэй холбоотой хэлэлцсэн асуудлуудын хууль эрх зүйн талаар зөвлөмж саналаа оруулж байна.

2016 онд хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах ажлын төлөвлөгөөг оны эхэнд баталж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллав. Аудитын үр дүн болон цаг үеийн ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүрт нь бэлтгүүлж ҮАГ-ын audit.mn вэб сайтад аудитын тайлан, мэдээллийг байршуулж ажиллав. Тайлант онд аудитын 16 тайлан, 6 удаагийн бусад мэдээллийг audit.mn вэб сайтад байршуулж, орон нутгийн радиогоор 16 удаа нэвтрүүлэг бэлтгэж явуулж, мэдээллийн самбарт аудитын дүнг мэдээлж байв.

Аудитын газраас 2016 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу аудитор, шинжээч, хувийн компаниудын аудиторуудыг оролцуулсан санхүүгийн аудитын сэдвээр дотоод сургалт зохион байгуулав.

ҮАГазраас зохион байгуулсан аудитын олон улсын стандартын сургалтанд бүх ажилтнууд хамрагдаж, хоёр шинжээч мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт өгч, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авснаар ажилтнуудын 80,0 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй аудиторууд болж байна.

Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын мэргэшлийн түвшин тогтоох журмын дагуу 4 ажилтан ҮАГ-т шалгалт өгч 90-95,0 оноогоор “А” үнэлгээгээр амжилттай дүн үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны “Журам, маягт, заавар батлах тухай” А/54 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ахлах аудитор, ахлах шинжээч нараар санхүүгийн тайлан, гүйцэтгэл, нийцлийн аудитын нэгтгэлийн маягтуудыг хариуцан хөтлөж ажиллуулах тухай тэргүүлэх аудиторовын тушаал гаргав.

ҮАГазарт Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага болон СТАУС программыг сайжруулах, Статистик мэдээ, тайлангийн шинэ маягтын загвар, Гүйцэтгэлийн аудитын журам, Аудитын чанарын хяналтын журам, Төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх журмын төслүүдэд тус тус санал бэлтгэж хүргүүллээ.

Ерөнхий менежерийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг гаргаж, аудитор, шинжээч нарын Ерөнхий менежертэй байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээг дүгнэхэд 2 ажилтан “В”, 8 ажилтан “А” үнэлгээ авч ажилтнуудын дундаж үнэлгээ 91,0 оноотой гарч байна.

ҮАГазраас ирүүлсэн хугацаат мэдээ, судалгаа, санал асуулгыг тухай бүрт нь гаргаж холбогдох газруудад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллаа.

Санхүүгийн тайлангийн аудитад илүү цаг ажилласан ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цагийн хөлсийг бодож олгон, эрүүл мэнд, ар гэрийн гачигдлаар чөлөө хүссэн ажилтнуудад 1-10 хоногийн цалинтай чөлөө олгож ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч ажиллав.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

7.1. Санхүүгийн тайлангийн талаар: - Тус газрын 2016 оны санхүүгийн тайлангаар нийт 59,3 сая төгрөгийн хөрөнгөтэй. Үүний 36,1 хувь буюу 21,4 сая төгрөг нь эргэлтийн хөрөнгө, 63,9 хувь буюу 37,9 сая төгрөг нь үндсэн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 216.0 мянган төгрөгөөр буурч оны эцэст үлдэглэлгүй байна. Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 268,0 мянган төгрөгөөр нэмэгдэж 2840,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарав. Үндсэн хөрөнгөнд орлого, зарлагын хөдөлгөөн гараагүй бөгөөд тайлант хугацаанд 15269,0 мянган төгрөгийн элэгдэл тооцож, тайлант хугацааны эцэст 30276,9 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Оны эхэнд 1344,2 мянган төгрөгийн авлагатай байсныг бүрэн барагдуулж, тайлант хугацааны эцэст авлагагүй гарсан. Оны эхэнд 110,6 мянган төгрөгийн өр төлбөртэй байсныг бүрэн барагдуулж оны эцэст өр төлбөргүй гарлаа.

Тайлант онд нийтдээ 278,0 сая төгрөгийн орлоготой, -15,0 сая төгрөгийн үр дүнтэй ажиллав.

7.2. Төсвийн гүйцэтгэлийн талаар: -Тус газар нь 2016 онд 260,2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 260,1 сая төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төсвөөс 93,9 мянган төгрөгөөр бага зардал гаргасан байна. Энэ нь нэг удаагийн тэтгэмж урамшуулалд батлагдсан төсвийн санхүүжилт дутуу олгодсонтой холбоотой гарсан хэмнэлт болно.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл үндсэн цалинд 184687,0 мянган төгрөгийг, унаа хоолны хөнгөлөлтөнд 4065,6 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 20432,8 мянган төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 11318,1 мянган төгрөгийг, дотоод албан томилолтонд 9923,6 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 11487,9 мянган төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 17929,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Шуудан холбооны зардал 132,0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 93,8 мянган төгрөгөөр хэмнэгдэж, бичиг хэргийн зардал 132,0 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

Тус газар нь 2013 оноос 1 орон тоогоор илүү ажиллаж ирсэн бөгөөд 2016 оны батлагдсан цалингийн сан, НДШ-ийн төсөв 14,0 сая төгрөгөөр хүрэлцэхгүй байсан тул аймгийн ИТХуралд хүсэлт тавьж санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрөөс 18,0 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэр гаргуулж, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулав. Үүний 12,0 сая төгрөгийг цалинд, 2,0 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд, 4,0 сая төгрөгийг автомашины сэлбэг хэрэгсэл, засварын зардалд зарцуулав.

Найм. Дүгнэлт, санал

Аудитын газар нь дотоод нөөц бололцоог ашиглан 2016 онд төлөвлөсөн ажлуудаа бүрэн хэрэгжүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитын явцад нэгдсэн удирдамжаар хийх гүйцэтгэл, нийцлийн аудит нь давхардаж хийгдэж байгаа нь ажлын ачаалал үүсгэж, аудитын үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Дараах саналуудыг хүргэж байна. Үүнд:

1.Байгууллагын төсвийн санхүүжилтийг бүрэн санхүүжүүлэх /хөдөө сумуудад ажиллах шатахуун, томилолтын зардал хүрэлцдэггүй/, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарах

2.Дотоод сүлжээний найдвартай ажиллагааг хангах, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

3.Байгууллагын автомашин олон жил ашиглагдаж хуучирсан, засвар үйлчилгээ ихээр шаарддаг, хөдөө орон нутгаар явахад найдваргүй тул шинэ автомашинтай болгох арга хэмжээ авч өгөх шаардлагатай байна.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР